

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ  
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН  
УЛААНБААТАР ЛИФТ НӨҮГ

**НЭГ. Товч танилцуулга<sup>1</sup>**

“Улаанбаатар лифт” НӨҮГ нь НИТХТ-ийн 2012 оны 06 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2012 оны А/184 дүгээр захирамжаар байгуулагдсан.

Үндсэн чиглэл:

Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууц, барилга байгууламжийн лифтийн засвар, техник үйлчилгээг гэрээгээр хариуцах, олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд магадлалын ажлыг гүйцэтгэх, улс, орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтэнд захиалагчийн хяналт хийх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, сургах.

Бүтэц орон тоо: 18 албан хаагч ажилладаг.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт :

Байгууллагын 2025 оны ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийсэн.

Ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбар, <http://ublift.ub.gov.mn/> цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж байна. Мөн ажилтнуудын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой мэдээлэл, гомдол саналыг байгууллагын өргөдөл гомдол хариуцсан албан хаагч нь цахимаар, утсаар, бичгээр ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлыг тухай бүрт нь хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

- Ёс зүй, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилж, байгууллагын цахим хуудсанд 5 мэдээлэл, хэвлэмэл хуудсаар 5 мэдээллийг тус тус байршуулсан. Мөн байгууллагын хурал зөвлөгөөн дээр ёс зүйтэй байх, авлигын эсрэг үйл ажиллагаа болон урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл зөвлөгөөг байнга өгч ажиллаж байна.

- 2025 онд байгууллагын [www.ublift.ub.gov.mn](http://www.ublift.ub.gov.mn) цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, АТГ-аас бэлтгэсэн хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байршуулан, тогтмол шинэчлэн нийтэд хүргэж ажилласан.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хүрээнд Нээлттэй мэдээллийг бэлтгэж, цахим хэлбэрээр байршуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.

“Соёл түгээе” уриан дор зохион байгуулагдсан “Соёлын орон зай – Бидний орчин” аянд нэгдэн соёлтой байж нэг нэгнийгээ хүндлэн урам зориг өгөхөөр энэхүү аяны хүрээнд контент бэлдэн цахимаар түгээж ажилласан.

“Технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд нэгдье” аянд нэгдэн албан хаагчдаа сургалтад хамруулсан.



<sup>1</sup> Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.



“Монгол төрийн албан хаагчийн ёс зүй”-н цахим сургалтад байгууллагын нийт албан хаагчид 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр хамрагдлаа.



НЗДТГ-ын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хандлага, гадаад дүр төрх” сургалтад 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Б.Уянга, Б.Лхагвасүрэн, Э.Номин-Эрдэнэ нар хамрагдлаа.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Төрийн албаны ёс зүйн хороо хамтран 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан “Ёс зүйн тухай хууль”-ийн сургалтад байгууллагын ёс зүйн хорооны гишүүд хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.



## 2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

1. Ёс зүйн зөрчил хүлээсэн албан хаагч байхгүй болно.
2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг цахим хуудсанд байршуулсан.
3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр газрын даргын 2025 оны “Ёс зүйн дэд хорооны гишүүдэд урамшуулал олгох тухай” Б/42 дугаар тушаалыг гарсан боловч зардлын эрх тавигдаагүй болно.



## 2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн, А/24 дүгээр тушаалаар Ёс зүйн зөвлөлийн даргаар Ахлах нягтлан бодогч Б.Уянга, гишүүнээр Архив, бичиг хэрэг, дотоод хэрэг хариуцсан мэргэжилтэн Э.Номин-Эрдэнэ, нарийн бичгийн даргаар Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал нар томилогдсон.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”, газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн, А/14 дүгээр тушаалаар Ёс зүйн дүрэм үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна. Албан хаагчийн

ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбар, <http://ublift.ub.gov.mn/> цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж ажилласан.



- Ёс зүйн зөвлөл 2025 онд 2 удаа хуралдаж, зөвлөлийн 2024 оны тайлан, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор албан хаагчдад зориулан явуулах сургалт, мэдээлэл, албан хаагчдаас авах санал асуулга, дүн шинжилгээг боловсруулах, дүгнэлт, зөвлөмж гаргах зэрэг асуудлаар хэлэлцэн шийдвэрлэж ажилласан.

- Байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэм хэмжээг тогтоож, ёс зүйн зарчим, хэм хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллагын нэр хүндийг хамгаалахад чиглэсэн ажлуудыг ёс зүйн зөвлөл удирдлага болгон ажиллаж байна.

- Үйл ажиллагаандаа "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай", "Авлигын эсрэг хуулийг тус тус мөрдөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгөх үүднээс Нийслэлийн эрх зүйн мэдээллийн санд 2017-2025 оны тушаалуудыг байршуулан авлигаас ангид ажиллаж байна.

Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээлэл 2025 онд байхгүй болно.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч албан хаагчдын хандлага, ёс зүйн харилцааны талаар мэдээллийн дагуу анхаарах асуудлуудыг тухай бүр илрүүлж, анхаарал хандуулан ажилласан бөгөөд ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилласан.	Хотын авто замын түгжрэлээс шалтгаалан эвдрэл гэмтлийг засварлах дуудлагад хугацаа хоцорч очих асуудал нь иргэд, СӨХ, ААНБ-уудын өргөдөл, гомдол санал гарах үндэслэл болдог.
Санал:	

**Шалгах хэсэг:**

- ✓ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ✓ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ✓ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ДАРГА

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА:  
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.ГАН-ЭРДЭНЭ

Б.УЯНГА

Ц.ӨСӨХЖАРГАЛ